

ОРХОН АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2016.01.20

Орхон аймаг

Д/Д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
Удирдлага зохион байгуулалт, авлигатай тэмцэх санал, санаачилга, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх чиглэлээр:					
1	Авлигын эсрэг үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх	Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, холбогдох байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд АТГ-т хүргүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	жилдээ	Хууль зүйн хэлтэс, хэлтэс, агентлагууд	Байгууллага бүр авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж, тайлагнаж хэвшсэн байна.
		Төрийн болон төрийн бус байгууллагаас гаргасан санал, санаачилгыг дэмжих, нэгдэх, авлигатай тэмцэх, авлигаас ангид байх хүсэл эрмэлзлээ илэрхийлэх, авлигын эрсдлийг бууруулах чиглэлээр тодорхой нэг ажлыг шинээр санаачлан жишиг байдлаар хэрэгжүүлэх	жилдээ	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Авлигын эрсдэл буурч, олон нийтээс төрийн байгууллагын үйл ажиллагааны шударга байдалд итгэх итгэл бий болно.
		Авлигын эсрэг үйл ажиллагаанд тодорхой хөрөнгийг төсөвлөх, зарцуулах	жилдээ		
2	Төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх	Төрийн албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, шударга байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	жилдээ	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Албан хаагчдын мэдлэг, шударга байдлын түвшин дээшилж, хариуцлагын тогтолцоо сайжирна.
		Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, дахин зөрчил гаргуулахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах	жилдээ		
		Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаа, ил тод байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт явуулж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	1-р улиралд	Аймгийн ЗДТГ, Хууль зүйн хэлтэс	Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж, авлигын эрсдэл буурна.
Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр:					
3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд шударга байдлыг төлөвшүүлэх талаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээллийн	Жилдээ	ХЗХ, төрийн бус байгууллагын сүлжээ, сумдын ЗДТГ	Авлигын эсрэг хууль

	иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх	бүх төрлийн арга хэлбэрийг ашиглан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх Авлигын эсрэг хууль тогтоомж, гарын авлагыг аймгийн вэб сайт, аймгийн ЗДТГ-ын мэдээллийн киоск, иргэний танхим, хорооллын нэг цонхны үйлчилгээний төв, бусад шаардлагатай газруудад байршуулах Erdenet.mn вэб сайтын “Авлигын эсрэг үйл ажиллагаа” буланд шаардлагатай мэдээллүүдийг тогтмол байршуулж, иргэд байгууллагыг мэдээллээр хангах	Жилдээ байнга Жилдээ байнга	Хууль зүйн хэлтэс	тогтоомжийн талаар мэдээлэл авах нөхцөл бүрднэ.
4	Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах Эрх бүхий албан тушаалтнууд болон ХАСХОМ мэдүүлэгчдийг чадавхижуулах, сургалт зохион байгуулах, холбогдох гарын авлага, материалаар хангах ажлыг зохион байгуулах	Жилдээ хуулийн хугацаанд 1-р улиралд	ТЗУХ сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд Аймгийн ЗДТГ, ТЗУХ	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлж хэвшинэ.
5	Шинээр боловсруулж буй бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, тэдний саналыг тусгах	Бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг аймгийн ЗДТГ-ын дэргэдэх “erdenet.mn” болон байгууллагын цахим хуудсанд байршуулах, иргэдээс санал авах нөхцлийг бүрдүүлэх Бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, сонирхогч бүлгийн саналыг авах, иргэд саналаа өгөх боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, саналыг шийдвэрт тусгах	Жилдээ тухай бүр жилдээ	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Шийдвэр гаргахад иргэдийн оролцоо нэмэгдэж, төрийн үйлчилгээг иргэдэд бодитойгоор хүргэх нөхцөл бүрдэнэ.
6	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг олон нийтэд мэдээлэх / цахим хуудсанд байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх г.м/ Шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах / дүгнэлт, акт, зөвлөмж, шийдвэр г.м/	жилдээ жилдээ	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Хяналт, хариуцлагын тогтолцоо сайжирна.
7	Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлэх Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, /1 дүгээр сарын 10-ны дотор/, хагас жилийн төсвийн гүйцэтгэл, / 08 сарын 15-ны дотор/ өмнөх оны төсвийн гүйцэтгэл, / 4-р сарын 25-ны дотор/, дараа жилийн төсвийн төсөл /9-р сарын 15-ны дотор/-ийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах Жилийн эцсийн санхүүгийн тайланг 04 сарын 25-ны дотор, хагас жилийн тайланг 8 сарын 15-ны дотор цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх /4 сарын 1-ний дотор/	Жилдээ хуулийн хугацаанд Жилдээ хуулийн хугацаанд	СТСХ, сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд СТСХ, сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	

		Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 сарын 25-ны дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Жилдээ тухай бүр	СТСХ, сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Төсөв санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн орлого, түүний зарцуулалтын талаарх мэдээлэл иргэдэд нээлттэй болж хяналт тавих нөхцөл бүрднэ.
		Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлэх	Жилдээ Тухай бүр	СТСХ, сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	
		- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, - 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг, - Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, - байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, - Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй ажилгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 7 хоногийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлэх / шилэн дансны мэдээлэлд/	Жилдээ Тухай бүр	СТСХ, сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	
		Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг эхийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд айлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчилж байх	жилдээ	Аймаг, сумдын ЗДТГ, Хэлтэс агентлагууд	
		Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах /цахим болон самбар, бусад хэлбэрээр /	Жилдээ тухай бүр	Хөгжлийн бодлогын хэлтэс, Сумдын ЗДТГ, харьяа хэлтэс, агентлагууд	
		Концессийн зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, концесс эзэмшигчийн талаарх мэдээллийн ил тод мэдээлэх	Тухай бүр	Хөгжлийн бодлогын хэлтэс	
8	Зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын хангах	Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт, түүнийг олгоход шаардагдах баримт бичиг, шийдвэрлэх журмын талаарх мэдээллийг ил тод болгох /цахим болон самбар бусад хэлбэрээр/	1-р улиралд	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	

		Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	жилдээ		
		Хуулиар хориглоогүй бүртгэлийн талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах /хууль тогтоомжид зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүд/	жилдээ		
9	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	Шинээр ажилтан сонгон шалгаруулах ажлыг ил тод нээлттэй байдлыг хангах /Сул орон тооны зар болон сонгон шалгаруулалт явуулах журам, сонгон шалгаруулалт явуулсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах, сонгон шалгаруулалтыг үндэслэн иргэдийг ажилд авах ажлыг зохион байгуулж хэвшүүлэх /	Жилдээ тухай бүр	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Хүний нөөцийн үйл ажиллагаа иргэдэд нээлттэй болно.
		Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчилж байх	Жилдээ тухай бүр		
10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө / 01 сарын 10-ны дотор/, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгарч чадаагүй үндэслэл шалтгааны талаарх мэдээллийг /7 хоногийн дотор/ хуулийн хугацаанд нийтэд мэдээлэх	Жилдээ тухай бүр	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд Худалдан авах ажиллагааны алба	Худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл иргэдэд нээлттэй болж, тогтолцооны шударга байдал хангагдна.
		Тендер шалгаруулах явцад гарсан зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх	Жилдээ тухай бүр		
		Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудас болон бусад хэлбэрээр хуулийн хугацаанд /7 хоногийн дотор/ нээлттэй мэдээлэх	Жилдээ тухай бүр		
		Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог хангаж хэвших	Жилдээ тухай бүр		
11	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх /дүрмийн төслийг АТГ-т хянуулж, өгсөн саналыг тусгах/	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх /дүрмийн төслийг АТГ-т хянуулж, өгсөн саналыг тусгах/	Жилдээ	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо бий болно.
		Ёс зүйн дүрмийн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх	жилдээ		

		Зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх / ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, зөвлөмж өгөх г.м/	Жилдээ тухай бүр		
12	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	Хууль болон засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулах, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх ажлыг хэрэгжүүлэх	жилдээ	ТЗУХ, сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Төрийн албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн талаар мэдээлэлтэй болж, хяналт тавих нөхцөл бүрдэнэ.
13	Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах, хариу өгөх үйл ажиллагааг боловсронгуй болгох	Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх цахим системийн үйл ажиллагааг өргөжүүлэн бүх төрийн байгууллагуудад нэвтрүүлэх	жилдээ	ТЗУХ	Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах шат дамжлага цөөрч, чирэгдэл багасна.
		Өргөдөл, гомдлыг хүлээн авах нөхцлийг бүрдүүлж, шуурхай шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг авч ажиллах	жилдээ	ТЗУХ сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	
		Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлж хэвших	Улирал бүр		
14	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх	2-р улиралд	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Авлигын эрсдэл буурна.
		Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал чирэгдлийг багасгах, ажлын байрыг сэлгүүлэх, зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх/	жилдээ		
15	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар АТГ-т мэдээлэх	Авлигын эсрэг хуульд заасны дагуу байгууллага, албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийн бүрэн эрхэд хамаарахгүй байвал АТГ-т мэдээлэх	Жилдээ тухай бүр	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Төрийн албан хаагчдын шударга байдлын түвшин нэмэгднэ.
16	АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, тайлагнах	АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн албан бичиг, АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн дагуу тодорхой арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон байх	жилдээ	Аймаг сумдын ЗДТГ, хэлтэс агентлаг, төрийн байгууллагууд	Ажил хэргийн уялдаа холбоо сайжирч, мэдээллийн шуурхай байдал хангагдна.

БОЛОВСРУУЛСАН: ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН АЖИЛТАН

Л.ТҮМЭННАСТ

ХЯНАСАН: ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

М.МӨНХБАЯР